



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан долоон аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан таван иргэн, аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Алтанбумба МандалХХК-ийн "Рич Хилл" зочид буудлын 13/56, Цогт Өргөө Од ХХК-ийн "Цогт Баян" зочид буудлын 13/99, Эх Хийморь ХХК-ийн "Хийморь" зочид буудлын 13/75, Ди Би Би ХХК-ийн "Хан-

Уул Тауэр” зочид буудлын 15/012 тоот, Иргэн Д.Рэгзэдмаагийн “Флимоне” дэн буудлын 13/117, Богд Өөд ХХК-ийн “Өлзий” зочид буудлын 13/173, Мөнх-Оюу ХХК-ийн “Анар” зочид буудлын 13/09, Төгөл Гоо ХХК-ийн “Бурхант-1” зочид буудлын 14/59, тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай

6. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.


7. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 19 өдрийн
А/90 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.09.19

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Мөнх-Оюу ХХК	Анар	Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 91
2	Богд-Өөд ХХК	Өлзий	Баянгол дүүрэг, 15-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө
3	Цогт Өргөө Од ХХК	Цогт Баян	Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, Цагдаагийн гудамж 43
4	Булгатмөрөн ХХК	Рояал Моунтайн	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Шаравын гудамж 6/17
5	Эх Хийморь ХХК	Хийморь	Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Үйлдвэрийн гудамж -17
6	Алтанбумба Мандал ХХК	Рич Хилл	Баянгол дүүрэг, 7-р хороо, Дилав хутагт Жамсранжавын гудамж
7	Төгөл гоо ХХК	Бурхант-1	Баянзүрх дүүрэг, 2-р хороо, Доржийн гудамж 76

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 19 өдрийн
А/90 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.09.19

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Төгөл гоо ХХК	Бурхант-1	Баянгол дүүрэг, 22-р хороо, Зүүннаран, 3-р хороолол 16090/61
2	Мандухай ХХК	Мандухай	Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 19 өдрийн
А/90 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2016.09.19

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Б.Халиун	Эра	Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 20/5
2	Дан Талст ХХК	Хас	Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс товчооны 25/02
3	Сүх Хайрхан ХХК	Цагаан Од	Сонгинохайрхан дүүрэг, 13-р хороо, 36-р сургуулийн ард өнөр 198/6
4	Голден Саякэл эшиа Песифик ХХК	Мийтинг Корнер	Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонсголонгийн зам 1/32
5	Иргэн Д.Рэгзэдмаа	Филимон	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, 15-р хороолол 386/1

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 09 сарын 19 өдрийн
А/90 дугаар тушаалын дөрөвдүгээр
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.09.19

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Манкур ХХК	Манкур	Баянгол дүүрэг, 16-р хороо, Туулын 19-386 тоот
2	Глади ХХК	Глади	Баянгол дүүрэг, 9-р хороо, Горькийн 1/23
3	ГББТ ХХК	Хаус-25	Баянгол дүүрэг, 6-р хороо, Жамсранжавын гудамж-72

-ooOoo-